САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

2020.01.17

*ТА **ИНТЕРНЕТ БАНК** БОЛОН **319708, 319709** УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.*

Валют	Ханш	24H Chg
EUR/USD	1.1138	0.01%
USD/CNY	6.8768	-0.03%
USD/RUB	61.6586	0.00%
USD/JPY	110.23	0.06%
USD/KRW	1158.65	-0.24%
USD/CHF	0.9648	0.36%
AUD/USD	0.6896	-0.04%
GBP/USD	1.3076	0.00%
Индекс	**Нэгж**	**24H Chg**
Dow Jones	29297.6	0.92%
S&P 500	3316.8	0.84%
NASDAQ	9357.1	1.06%
FTSE 100	7609.8	-0.43%
Nikkei 225	24060.9	0.53%
DAX	13429.4	-0.02%
Hang Seng	28883.0	0.38%
SHCOMP	3074.1	-0.52%
Метал	**Ханш (USD)**	**24H Chg**
Алт	1550.56	-0.13%
Мөнгө	17.9214	-0.12%
Нүүрс (Чин хуанг дао/юань)	556	0.91%
Хүрэн нүүрс (БНХАУ)	33.3	-0.09%
Зэс (LME)	6277.5	-0.15%
Төмрийн хүдэр	664.5	0.08%
Газрын тос (NYME)	58.56	0.07%
Бонд	**Хүү**	**24H Chg**
US 1M LIBOR	1.67%	-0.04%
US 3M LIBOR	1.84%	-0.35%
US 6M LIBOR	1.87%	0.03%
US 12M LIBOR	1.95%	-0.53%
US Treasury 10Y	1.82%	0.77%
UK Treasury 10Y	0.64%	-1.68%
GE Treasury 10Y	-0.22%	-9.50%
JP Treasury 10Y	0.01%	-20.00%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24H Chg
Гэрэгэ	5.63%	5/1/2023	4.40%	0.01%
Мазаалай	10.8%	4/6/2021	3.39%	0.00%
Хуралдай	8.75%	3/9/2024	4.79%	-0.04%
Чингис	5.13%	12/05/2022	4.17%	0.03%
ХХБ 2020	9.38%	5/19/2020	3.96%	-0.06%
Самурай	5.75%	12/25/2023	0.72%	0.02%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	5.20%	-0.12%
МИК 2022	9.75%	1/29/2022	10.60%	0.21%

Онцлох мэдээ

- Ройтерс агентлагийн санал асуулгаар шинжээчид БНХАУ-ын 4-р улирлын эдийн засгийг урьд оны мөн үеэс 6% өсөж, 1992 оноос хойших хамгийн удаашралтай үе болж байгаа гэж төсөөлж байна.
- Өмнөд Солонгос улсын Төв банк бодлогын хүүгээ 1.25%-д хэвээр үлдээсэн нь Ройтерс агентлагийн 33 шинжээчдийн дундах санал асуулгын таамаглалтай таарлаа.
- АНУ-ын ХҮИ 12-р сард өмнөх сараас 0.2%, өмнөх оны мөн үеэс 2.3% тус тус өсжээ.

Валютын зах зээл

Өчигдөр буюу Пүрэв гарагт АНУ-ын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд маш сайн гарсан нь Америкийн хувьцаануудын ханшийг өсгөж улмаар ам.доллар чангарлаа. Өнгөрсөн 12-р сард автомашиныг оруулаагүй жижиглэн худалдааны үзүүлэлт таван сарын хугацаанд хамгийн их өсөлттэй гарсан ба Филадельфи хотын нөөцийн банкны бизнесийн төлөв байдал 5-р сараас хойш хамгийн сайн үзүүлэлтийг харуулсан нь ам.долларын ханшийг өсгөхөд түлхэц болж өгчээ.

Их Британийн засгийн газрын бондуудын өгөөж буурч мөн Английн төв банк бодлогын хүүг бууруулах магадлал өссөн ч Английн фунтын ханш 3 дахь өдрөө дараалан чангараад байна. Их Британийн 12-р сарын жижиглэн худалдааны мэдээ зарлагдахаас өмнө фунтын ханш ам.долларын эсрэг 1.3071 дээр хэлбэлзэж байна. Шинэ Зеланд улсын жижиглэн худалдааны зарцуулалт хангалттай дүнтэй гарсан нь долларын ханшийг 0.6640 нэгжид хүргэлээ. Төгрөгийн ханш ам.долларын эсрэг албан ханшаар 1.64 нэгжээр сулран 2744.02-д хаагдсан. Харин голлох банкуудын бэлэн бус зарах дундаж ханш 2748 төгрөг болж өссөн байна. Өчигдөр гадаад валютын ээлжит дуудлага худалдаагаар Монголбанк 38.9 сая ам.долларыг нэг ханшаар нийлүүлжээ.

Алтны зах зээл

АНУ-ын эдийн засгийн тоон мэдээ хүлээгдэж байсан үр дүнгээс сайн гарсан бол АНУ-Хятад худалдааны 1-р үе шатны хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа хөрөнгийн зах зээл сэргэж алтны үнэ буурлаа. Нэгдсэн улсын жижиглэнгийн худалдаа 12 сард өсөж гарсан нь 3 сар дараалсан өсөлт болсон бөгөөд Атланта мужийн үйлдвэрлэлийн салбар 8 сарын дээд хэмжээндээ хүрсэн байна. АНУ-ын баярын худалдаа 2019 онд өмнөх оноос 4.1% өссөн ба тогтвортой ажлын байр цалин хөлсний өсөлт өргөн хэрэглээний барааны худалдан авалтад нөлөөлсөн гэж Үндэсний жижиглэн худалдааны холбоо мэдээлсэн. Спот алтны ханш 0.3% буурч нэг унц нь 1,551.53 ам.долларт хүрсэн байна.

Хувьцаа	Ханш	24H Chg
Turquoise Hill Resources	0.6934	1.90%
Mongolian Mining Corp	0.57	-5.00%
Mongolian Energy Corp	0.22	7.32%
Centerra Gold	9.54	-3.25%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2019 (XI)	5.2%
Бодлогын хүү	2019 (XI)	11.0%
Банк хооронын зах зээлийн хүү	2019 (XI)	11.2%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2019 (XI)	11.5%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2019 (XI)	4.8%
Зээлийн дундаж хүү (төг)	2019 (XI)	16.9%
Зээлийн дундаж хүү (валют)	2019 (XI)	10.6%

Ханшийн таамаглал

Валют	Q1 20	Q2 20	Q3 20	Q4 20	2021
EUR/USD	1.12	1.13	1.14	1.15	1.18
GBP/USD	1.32	1.32	1.33	1.35	1.4
USD/CNY	7.03	7.05	7.09	7.1	7.22
USD/JPY	108	108	107	106	109
USD/RUB	64	64	64.25	64	65.94
Түүхий эд					
Алт	1518	1528	1538	1544	1561
Зэс	6218	6230	6238	6200	6265
Нүүрс	62.25	59.75	60	60	59.94

эх сурвалж: Блүмбэрг

Эдийн засгийн голлох тоо мэдээ

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
GE HICP Final YY	1.50%	1.50%	1.50%
US Initial Jobless Claims	204k	216k	214k
US Philly Fed Business Indx	17	3.8	0.3
US Retail Sales MM	0.30%	0.30%	0.20%
Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
UK Retail Sales MM	17:30	0.50%	-0.60%
UK Retail Sales YY	17:30	2.60%	1.00%
IT CPI (EU Norm) Final YY	18:00	0.50%	0.50%
US Industrial Production MM	22:15	-0.20%	1.10%
US U Mich Sentiment Prelim	23:00	99.3	99.3
Маргааш хүлээгдэж буй мэдээ	**Цаг**	**Таам.**	**Өмнөх**
GE Producer Prices MM	15:00	-	0.00%
GE Producer Prices YY	15:00	-	-0.70%

Зэсийн зах зээл

Сүүлийн 2 арилжааны турш унаад байсан зэсийн үнэ 2019 онд удаашралтай байсныг харуулах БНХАУ-ын эдийн засгийн тоон мэдээ зарлагдахын өмнө бага зэрэг өөрчлөлттэй арилжаалагджээ. Лондонгийн Металлын Бирж дээр өнөөдрийн арилжаагаар зэсийн ханш 6,280 ам.долларт арилжаалагдсан бол Шанхайн Фьючерсийн Бирж дээр 0.1% буурч 7,155.94 ам.доллар хүрсэн байна.

Өчигдөр эхний шатны худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурагдсаны дараа АНУ-ын Сангийн сайд Стивин Мнучин “тариф тогтоосон хэвээр үлдсэн гэхдээ Хятадын талаас дараагийн шатны хэлэлцээрийг хийхээр түргэвчилбэл ерөнхийлөгч Трамп тарифыг бууруулах талаар авч үзнэ “ гэжээ.

Газрын тосны зах зээл

Өнөөдөр зарлагдах БНХАУ-ын сүүлийн 29 жилийн хугацаан дахь хамгийн удаашралтай эдийн засгийн мэдээг хөрөнгө оруулагчид хүлээж газрын тосны үнэ тогтуун байлаа. Брент болон WTI өглөөний арилжаагаар харгалзан 3; 6 центээр өсөж нэг баррел нь 64.65 болон 58.58 ам.долларт хаагдсан байна.

Эхний шатны худалдааны хэлэлцээрт Хятад улс АНУ-с эхний жилд 18.5 тэрбум ам.долларын, дараагийн жилд 33.9 тэрбум ам.долларын эрчим хүчний бүтээгдэхүүн худалдан авахаар тохиролцсон байна.

Бондын зах зээл

Франц улсын “Societe Generale” банк олон улсын зах зээлд 3 тэрбум ам.долларын бондыг 2 хуваж гаргахаар боллоо. 1.75 тэрбум ам.долларыг 5 жилийн хугацаатай гаргаж байгаа бол үлдсэн 1.25 тэрбум ам.долларыг 10 жилийн хугацаатай арилжаалахаар боллоо. Мөн олон улсын “Morgan Stanley” байгууллага олон улсын зах зээлд 6 тэрбум ам.долларын бондыг мөн адил 2 хуваж гаргахаар боллоо. 3.5 тэрбум ам.долларыг 11 жилийн хугацаатай, 2.699%-н хүүтэй гаргаж байгаа бол үлдсэн 2.5 тэрбум ам.долларыг 3 жилийн хугацаатай, хөвөгч хүүтэйгээр санал болгожээ.

Хөрөнгийн зах зээл

Пүрэв гарагт жижиглэн борлуулалтын мэдээ болон Morgan Stanley компанийн улирлын орлого, технологийн салбарын хувьцааны огцом өсөлтөөс шалтгаалж голлох индексүүд өссөн бөгөөд S&P 500 индекс анх удаа 3,300 нэгжийг давлаа. Эдийн засагчдын хүлээлтийн дагуу жижиглэн худалдаа 12-р сард 0.3% өссөн үр дүнг харуулсан байна. Голлох индексүүд: Dow +0.92%, S&P 500 +0.84%, Nasdaq +1.06%.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мейлд хариу илгээнэ үү.